PEACE & PERFECT
AUDIT LLC



“ПИЙС ЭНД ПЕРФЕКТ АУДИТ” ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар
болсон санхүүгийн тайлангийн тухай

2024 он

“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК

2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ 3
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ 4
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН 5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 7
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН 8
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 10
ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 11
ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО 11
ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС 15
ТОДРУУЛГА 4. ЗЭЭЛ 15
ТОДРУУЛГА 5. БУСАД АВЛАГА 15
ТОДРУУЛГА 6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ 16
ТОДРУУЛГА 7. ЭЗДИЙН ӨМЧ 16
ТОДРУУЛГА 8. ХҮҮГИЙН ОРЛОГО 16
ТОДРУУЛГА 9. ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ 17
ТОДРУУЛГА 10. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ 17
ТОДРУУЛГА 11. ЗОХИСТОЙ БАЙДЛЫН ХАРЫЦАА 19
ТОДРУУЛГА 12. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ 20
ТОДРУУЛГА 13. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА 20
ТОДРУУЛГА 14. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР 20
ТОДРУУЛГА 15. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ 20
ТОДРУУЛГА 16. ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ 20

Peace & Perfect Audit
Page № 2

“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК

БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр	“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК
Хариуцлагын хэлбэр	Банк бус санхүүгийн байгууллага хязгаарлагдмал хариуцлагатай компани
Байгууллагын эрх барих дээд байгууллага	Хувьцаа эзэмшигчид: - Н.Нямдорж 62 хувь - Т.Нямдаваа 38 хувь эзэмшдэг байна.
Регистрийн дугаар	5849179
Үүсгэн байгуулагдсан огноо	2014.05.28
Үйл ажиллагааны чиглэл	Зээлийн үйл ажиллагаа
Тусгай зөвшөөрөл	СЗХ-ны 2014.08.06 өдрийн №284 тогтоол, ТЗ 101/395
Удирдлага	Гүйцэтгэх захирал Т.Ариунжаргал 2018 онд томилогдсон.
Ажиллагсдын тоо	4
Харъяалах татвар, нийгмийн даатгалын хэлтэс	Нийслэлийн Санхүү, төрийн сан, Хан-Уул дүүргийн татварын хэлтэс, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс
Хаяг	УБ, ХУД, 15-р хороо, Стадион Оргил, Эм Эс Эн бюлдинг, 302 тоот, 94663333, tsencredit@gmail.com
Аудитор	Пийс энд Перфект аудит ХХК, Хараат бус баталгаажуулалт, санхүүгийн үйлчилгээний итгэмжлэгдсэн байгууллага Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Ситиюс, 6 давхар 604 тоот Утас: 80116813 E-mail: peaceandperfectaudit@gmail.com

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Ариунжаргал болон Ерөнхий нягтлан бодогч Н.Нямдорж 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх байгууллагын санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.АРИУНЖАРГАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ Н.НЯМДОРЖ

Peace & Perfect Audit

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

"ЦЭНКРЕДИТ ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Ариунжаргал болон Ерөнхий нягтлан бодогч Н.Нямдорж 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх байгууллагын санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.АРИУНЖАРГАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ Н.НЯМДОРЖ

Peace & Perfect Audit
Page №. 4.

PEACE & PERFECT AUDIT LLC

“ПИЙС ЭНД ПЕРФЕКТ АУДИТ” ХХК

2024 оны 3 дугаар сарын 18-ний өдөр

№..А24/019 **Улаанбаатар хот, Монгол улс**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК-ийн Удирдлага-д

Дүгнэлт

Бид **“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК** (цаашид “Компани” гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, **“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК-ийн** 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан. Бид Монгол Улсын “Аудитын тухай” хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулиар шаардсан шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид найдаж байна.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн яамнаас гаргасан холбогдох заавар, журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.
Засаглах удирдлага нь байгууллагын санхүүгийн тайлагналын процест хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

Ул үндэслэлтэй баталгаа нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудын талаар аудитын нотлох зүйл олж авах түүврийн горимыг гүйцэтгэх ажил багтана.

Сонгон авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдэлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна.
Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлыг харгалзаж үздэг ба энэ талаар дүгнэлт гаргах зорилгоор бишэ, зөвхөн тухайн нөхцөлд зохистой аудитын горимуудыг тодорхойлоход чиглэдэг. Мөн аудитын ажилд удирдлагын хийсэн томоохон тооцооллууд болон баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг үнэлэх ажлууд багтана.

"ПИЙС ЭНД ПЕРФЕКТ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

..... **Ч.НОМИНЧУЛУУН**

Сухбаатар дүүрэг, 9-р хороо, Ситиюс төвийн 6-р давхарт
604 тоот, Улаанбаатар хот, Монгол Улс
Утас:976- 80116813
И-мэйл: peaceandperfectaudit@gmail.com

“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
Хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах зүйлс	**3**	1,096,670,611.10	197,891,166.94
Зээл /цэврээр/	**4**	2,071,967,483.63	4,240,447,155.56
Бусад авлага	**5**	758,935,116.27	583,998,576.16
Үндсэн хөрөнгө /цэврээр/	**6**	158,290,659.07	142,401,509.07
Биет бус хөрөнгө /цэврээр/		2,492,855.90	2,078,353.90
Нийт хөрөнгө		**4,088,356,725.97**	**5,166,816,761.63**
Өр төлбөр ба эздийн өмч			
Богино хугацаат өр төлбөр		22,932,107.01	2,000.00
Нийт өр төлбөр		**22,932,107.01**	**2,000.00**
Өөрийн хөрөнгө	7		
Хувьцаат капитал		2,067,920,000.00	2,670,000,000.00
Хуримтлагдсан ашиг		1,997,504,618.96	2,496,814,761.63
Өөрийн хөрөнгийн дүн		**4,065,424,618.96**	**5,166,814,761.63**
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		**4,088,356,725.97**	**5,166,816,761.63**

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Peace & Perfect Audit
Page № . . 7

“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
Хүүгийн орлого	8	977,918,698.79	878,344,639.10
Хүүгийн зардал		-	-
Цэвэр хүүгийн орлогын дүн		**977,918,698.79**	**878,344,639.10**
Хүүгийн бус орлого		-	1,695,392.00
Хүүгийн бус зардал	9	(110,742,235.81)	(136,798,351.85)
Цэвэр хүүгийн бус орлогын дүн		**(110,742,235.81)**	**(135,102,959.85)**
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал		**867,176,462.98**	**743,241,679.25**
Болзошгүй эрсдлийн зардал		(253,754,800.00)	(188,250,000.00)
Үндсэн үйл ажиллагааны ашиг/ алдагдал		**613,421,662.98**	**554,991,679.25**
Үндсэн бус үйл ажиллагааны бус зардал		(7,052,000.00)	(182,368.65)
Татвар төлөхийн өмнөх ашиг		**606,369,662.98**	**554,809,310.60**
Орлогын татварын зардал		(6,134,216.53)	(55,499,167.93)
Цэвэр ашиг		**600,235,446.45**	**499,310,142.67**

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Peace & Perfect Audit
Page № . . 8

"ЦЭНКРЕДИТ ББСБ" ХХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Дүн
2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	**2,067,920,000.00**	**1,332,289,600.00**	**3,400,209,600.00**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	**2,067,920,000.00**	**1,332,289,600.00**	**3,400,209,600.00**
Тайлант үеийн цэвэр ашиг	-	600,235,400.00	**600,235,400.00**
Ногдол ашиг	-	-	-
Хувьцаат капиталын өсөлт	-	64,979,600.00	**64,979,600.00**
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**2,067,920,000.00**	**1,997,504,600.00**	**4,065,424,600.00**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	18.96	18.96
Залруулсан үлдэгдэл	**2,067,920,000.00**	**1,997,504,618.96**	**4,065,424,618.96**
Тайлант үеийн цэвэр ашиг	-	499,310,142.67	499,310,142.67
Ногдол ашиг	-	-	-
Хувьцаат капиталын өсөлт	602,080,000.00	-	602,080,000.00
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**2,670,000,000.00**	**2,496,814,761.63**	**5,166,814,761.63**

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болн

Peace & Perfect Audit
Page № . 9

"ЦЭНКРЕДИТ ББСБ" ХХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

Төгрөгөөр

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	**2,128,242,821.81**	**4,730,533,574.87**
Зээлийн хүүгийн орлого	736,540,411.61	999,737,084.79
Харилцах дансны хүүгийн орлого	-	35,141.29
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	-	3,673,270,328.07
Бусад үйлчилгээний орлого	1,391,702,410.20	57,491,020.72
Мөнгөн зарлагын дүн (-)	**1,762,678,826.72**	**6,231,210,650.38**
Үндсэн ба нэмэгдэл цалин	41,177,657.68	63,607,363.66
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	13,402,442.97	18,136,352.59
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	1,865,708.01	696,186.98
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	9,313,797.86	6,504,512.83
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	706,415.00	1,577,409.00
Татвар, даатгалын төлсөн мөнгө	82,198,611.09	87,527,391.61
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	100,000.00	100,000.00
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	87,297.00	413,800.00
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	2,480,000.00	2,963,900.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,000,000.00	2,700,000.00
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	1,590,000,000.00	6,030,000,000.00
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	18,346,897.11	16,983,733.71
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**365,563,995.09**	**(1,500,677,075.51)**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	**68,373,633.42**	**602,080,000.00**
Бусад	68,373,633.42	602,080,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	**7,044,000.00**	**182,368.65**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	7,044,000.00	-
Торгуулийн зардал	-	130,000.00
Бусад	-	52,368.65
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**61,329,633.42**	**601,897,631.35**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**426,893,628.51**	**(898,779,444.16)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**669,776,982.59**	**1,096,670,611.10**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**1,096,670,611.10**	**197,891,166.94**

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

Peace & Perfect Audit
Page № 10

ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Байгууллагын үүсгэн байгуулалт

Компани нь 2014 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Н.Нямдорж 62 хувь, Т.Нямдаваа 38 хувийн хөрөнгө оруулж хувь эзэмшдэг байна. Байгууллага 4 ажилтантай. Байгууллагын өдөр тутмын шийдвэр гаргах, үйл ажиллагааг гүйцэтгэх захирал Т.Ариунжаргал гүйцэтгэдэг.

1.2 Үйл ажиллагааны чиглэл

- Зээлийн үйл ажиллагаа

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй “Аудитын тухай” хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материал үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

2.1 Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал

Тус байгууллагын 2023 оны Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр тайлангуудад хийсэн нэмэлт тодруулгаас бүрдсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийг “Интерактив Би Ай” ХХК-ийн программ болох “Снипел 6.0”-ийн цогц программыг ашиглан хөтөлдөг байна.

Компани нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан, тодруулгуудыг бэлтгэсэн байна.

2.2 Санхүүгийн тайлагналын суурь

Компани нь удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчмаар, аккруэл сууриар бэлтгэгдсэн байна.

2.3 Санхүүгийн тайланг бэлтгэсэн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайланг Байгууллагын үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох Монгол Улсын төгрөгөөр илэрхийлсэн.

2.4. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

“Цаашид ч гэсэн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ” гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. Дээрх тасралтгүй үйл ажиллагааны талаарх төсөөлөл, үр дүн нь тодорхойгүй байгаа ирээдүйд болж болох үйл явцад суурилсан байна.

2.5. Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн гадаад валют болон суурь валютын хоорондох валютын ханшийг ашиглаж, гадаад валютын дүнг суурь валютад хөрвүүлэн анхны хүлээн зөвшөөрөлтөөр бүртгэдэг.

Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлнэ.

Хөрвүүлэлтээс үүдсэн ханшийн зөрүүг орлогын тайланд бүртгэнэ. Орлогын тайлангийн үзүүлэлтүүдэд хамааралтай гадаад валютаарх ашиг, алдагдлыг орлогын дэлгэрэнгүй тайланд бусад орлогын хэлбэрээр толилуулна.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлнэ.

Монголбанкны 2010 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс “ТУХАЙН ӨДРИЙН ХААЛТЫН ХАНШ”-ийг Монголбанкнаас зарласан дараа өдрийн ханш гэж тооцно гэсэн зааврын дагуу 2023 оны 12 сарын 30-нд ам.долларын төгрөгтэй харьцах ханш 3,410.69 төгрөг байв.

2.6. Шинэ болон өөрчлөлт орсон стандартын хэрэглээ

Компани нь Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ) болон СТОУС-ын тайлбарын хороо (СТОУСТХ)-ноос гаргасан 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш хүчин төгөлдөр үйлчлэх бүх шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартыг авч хэрэгжүүлсэн.

2.6. Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого

Компани нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ дараах бүртгэлийн бодлогуудыг баримталдаг байна.

2.6.1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Байгууллагын хувьд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь төгрөгийн касс, банкин дахь төгрөг, ам.доллар түүнтэй адилтгах зүйлсээс бүрддэг.

Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн дансдын үлдэгдлийг балансын өдрөөрх Монгол банкны ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг.

2.6.2 Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад бэлэн мөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, дансны авлага болон бусад авлага өглөгөөс бүрдэнэ.

Санхүүгийн хөрөнгүүдийг эхэлж бодит үнэ цэнээр нь бүртгэх ба бүх худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь, зээл болон зээллэгийг шууд хамааралтай зээлийн зардлын нийлбэр дүнгээр хүлээн зөвшөөрнө. Байгууллагын санхүүгийн өр төлбөрт дансны өглөг, бусад өглөг, зээл, зээлийн хүүгийн өглөг багтана.

Авлага

Зээл болон авлага нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй үүсмэл биш санхүүгийн хөрөнгө юм.

Байгууллагын авлага нь зээлийн авлага болон хуримтлуулж тооцсон хүүгийн авлагаас үүснэ.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

Peace & Perfect Audit

Урьдчилж төлсөн төлбөрүүд

Урьдчилж төлсөн төлбөр нь урьдчилж бэлэн мөнгө төлсөн боловч бодитоор гараагүй байгаа зардлыг хэлнэ. Урьдчилж төлсөн төлбөрүүд нь эхлээд төлсөн мөнгөн дүнгийн хэмжээгээр хөрөнгөөр бүртгэгдэнэ. Харин дараа тайлант үед гэрээний дагуу эсвэл дараа хугацаанд үйл ажиллагаа нь хэрэгжсэн, хугацаа нь дуусахад орлогын тайланд тусгагддаг.

2.6.3. Бараа материал

Бараа материалын өртөг тодорхойлох. Худалдан авсан бараа материалын өртөг нь худалдан авсан үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой гарсан бэлтгэл ажиллагааны зардлаас бүрдэнэ. Бэлтгэл ажиллагааны зардлыг хуваарилахдаа үнийн дүнгийн аргыг ашигладаг.

2.6.4. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгөнд газрын сайжруулалт, барилга, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер түүний дагалдах хэрэгсэл, бусад хөрөнгүүд хамаарна.

Өртөг. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, тухайн хөрөнгийг зориулалтын байршил, нөхцөлд ашиглалтанд оруулахтай холбогдсон бусад зардлаас бүрдэнэ.

Хөрөнгийг ашиглалтанд оруулсан үеэс хойш гарсан зардлуудыг тухайн хөрөнгийг ашигласнаас бий болохоор хүлээгдэж буй эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байгаа эсэхийг харгалзан үзэж, тайлант үеийн зардал болон хөрөнгийн нэмэлт өртөг болгон капиталжуулах эсэхийг нь тодорхойлдог.

Үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдэл болон үнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнагдсан.

Элэгдэл. Үндсэн хөрөнгийг ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдэл тооцдог. Тайлант хугацаанд байгуулсан элэгдлийг элэгдлийн зардлаар бүртгэдэг.

Компани нь үндсэн хөрөнгийг элэгдүүлэхдээ дараах хугацааг баримталдаг. Үүнд:

Барилга, байгууламж	25 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер	2 жил
Бусад хөрөнгө	10 жил

2.6.5. Орлого

Эдийн засгийн үр ашиг нь компанид орох магадлалтай болсон ба орлогыг бодитойгоор хэмжих боломжтой болсон үед хүлээн зөвшөөрнө.

2.6.6. Зардал

Санхүүгийн хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг нэмэгдүүлэх байдлаар эдийн засгийн үр өгөөж буурах ба түүнийг бодитой хэмжих боломжтой үед зардлыг ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Зардлыг ашиг, алдагдлаар бүртгэхдээ тухайн гарсан зардлыг олсон орлоготой нь уялдуулж бүртгэх, хэрвээ эдийн засгийн өгөөж нь хэд хэдэн тайлангийн хугацаа дамнан орж ирэхээр бол түүнчлэн зардал ба орлогын уялдаа холбоо шууд тодорхойлогдохгүй, өргөн цар хүрээгээр холбогдож байвал зардлыг системтэй ба зүй зохистой аргаар хуваарилж бүртгэнэ.

Хэрэв зардал нь ирээдүйн өгөөжийг бий болгоогүй, эсвэл ирээдүйн эдийн засгийн өгөөж нь санхүүгийн байдлын тайлан дээр хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангахгүй эсвэл хангаж чадахгүй болсон тохиолдолд зардлыг шууд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

2.6.7. Зээлийн зардал

Компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор арилжааны банк болон бусад эх үүсвэрээс авсан зээлийн зардал нь НББОУС 23-д заасан бэлтгэл шаардагдах хөрөнгийн шаардлагыг хангахгүй байвал тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Peace & Perfect Audit
Page № 13

Бэлтгэл шаардагдах хөрөнгө гэдэг нь зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулахад зориулж бэлтгэхэд үлэмж хэмжээний цаг хугацаа зайлшгүй шаарддаг хөрөнгө юм.

2.6.8. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөг юм.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцоололд ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын дансны үнийг тайлант хугацаа бүрийн эцэст хянах ба хангалттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн тухайн өр төлбөрийг барагдуулах эсвэл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тайлант онд мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт нь тайлант хугацааны эцэст компани хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулахаар хүлээж байгаагаас үүсэх татварын үр дагаварт нөлөөлнө.
Тус компани нь албан татвар төлөгч хуулийн этгээдийн хувьд Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасны дагуу тодорхойлоход 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар төлөх үүрэгтэй.
Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д энэ хуулийн 20.1-д заасныг үл харгалзан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар төлнө.

2.6.9. Нэмэгдсэн өртгийн албан татвар

Компани нь НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.7-т заасны дагуу үндсэн үйл ажиллагааны орлого татвараас чөлөөлөгдөнө.

2.6.10. Бусад татвар

Компани нь Монгол Улсын татварын бусад хуулийн дагуу дараах татварын төрлийг төлдөг. Үүнд: автотээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр болон бусад татварууд хамаарна.
Мөн байгууллагын ажиллагсдын цалингаас сар бүр ноогдох ХХОАТ-ыг хуульд заасан хувь хэмжээгээр суутган авч татварын албатай тооцоог хийдэг.

2.6.11. Ажиллагсадтай холбоотой цалин, тэтгэмж

Богино хугацааны тэтгэмж:

Компани нь ажиллагсдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах зүйлсийг тухайн жилийн цалингийн зардалд хүлээн зөвшөөрнө. Мөн ажилтнуудад ээлжийн амралт, өвчтэй хугацааны тэтгэмжийг хуулийн дагуу олгодог байна.

Тодорхой хураамжууд:

Компани нь хуулийн дагуу эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг 12.5 хувиар тооцож, тухайн жилийн зардалд хүлээн зөвшөөрнө.

Peace & Perfect Audit
Page №. 14

ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС

Тайлант хугацааны эцсээрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Ангилал	2022.12.31	2023.12.31
Бэлэн мөнгөний кассын үлдэгдэл:		
Касс	177,649,461.32	45,287,503.76
Бэлэн мөнгөний кассын дүн	**177,649,461.32**	**45,287,503.76**
Банкин дахь харилцах дансны үлдэгдэл:		
Хаан банк	907,454,270.78	125,704,822.24
Голомт банк	6,073,728.32	21,405,690.26
Банкин дахь харилцах дансны дүн	**913,527,999.10**	**147,110,512.50**
Банкин дахь хадгаламжийн дансны үлдэгдэл:		
Хаан банк	5,493,150.68	5,493,150.68
Банкин дахь хадгаламжийн дансны дүн	**5,493,150.68**	**5,493,150.68**
	1,096,670,611.10	**197,891,166.94**

ТОДРУУЛГА 4. ЗЭЭЛ

Тайлант хугацааны эцсээрх зээлийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Ангилал	2022.12.31	2023.12.31
Зээл		
Хэвийн зээл	1,818,212,673.20	3,771,942,345.13
Хугацаа хэтэрсэн зээл	-	-
Чанаргүй зээл		
-Хэвийн бус	-	53,000,000.00
- Эргэлзээтэй	507,509,620.87	857,509,620.87
- Муу	199,000,000.00	199,000,000.00
Зээлийн эрсдэлийн сан	452,754,810.44	641,004,810.44
Зээлийн цэвэр дүн	**2,071,967,483.63**	**4,240,447,155.56**

ТОДРУУЛГА 5. БУСАД АВЛАГА

Тайлант хугацааны эцсээрх авлагын үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Ангилал	2022.12.31	2023.12.31
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	703,727,167.55	582,299,580.57
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлагын дүн	**703,727,167.55**	**582,299,580.57**
Орлогын албан татварын авлага	55,207,948.72	1,696,995.59
ХХОАТ-ын авлага	-	2,000.00
Бусад авлагын дүн	**55,207,948.72**	**1,698,995.59**
Авлагын дүн	**758,935,116.27**	**583,998,576.16**

Peace & Perfect Audit
Page № . . 15

ТОДРУУЛГА 6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Тайлант хугацааны эцсээрх үндсэн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	Компьютер, бусад хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Нийт
Өртөг				
2022.12.31 үлдэгдэл	**3,131,000.00**	**3,038,000.00**	**185,000,000.00**	**191,169,000.00**
Нэмэгдсэн	*2,999,900.00*	-	-	**2,999,900.00**
2023.12.31 үлдэгдэл	**6,130,900.00**	**3,038,000.00**	**185,000,000.00**	**194,168,900.00**
Хуримтлагдсан элэгдэл				
2022.12.31 үлдэгдэл	**3,045,750.00**	**2,082,590.93**	**27,750,000.00**	**32,878,340.93**
Нэмэгдсэн	85,250.00	303,800.00	18,500,000.00	**18,889,050.00**
2023.12.31 үлдэгдэл	**3,131,000.00**	**2,386,390.93**	**46,250,000.00**	**51,767,390.93**
Цэвэр дүн				
2022.12.31 үлдэгдэл	**85,250.00**	**955,409.07**	**157,250,000.00**	**158,290,659.07**
2023.12.31 үлдэгдэл	**2,999,900.00**	**651,609.07**	**138,750,000.00**	**142,401,509.07**

ТОДРУУЛГА 7. ЭЗДИЙН ӨМЧ

Ангилал	2022.12.31	2023.12.31
Өмч:		
Хувьцаат капитал	2,067,920,000.00	2,670,000,000.00
Өмчийн дүн	**2,067,920,000.00**	**2,670,000,000.00**
Хуримтлагдсан ашиг, (алдагдал):		
Тайлант үеийн ашиг, (алдагдал)	600,235,436.01	499,310,142.67
Өмнөх үеийн ашиг, (алдагдал)	1,397,269,182.95	1,997,504,618.96
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)-ын дүн	**1,997,504,618.96**	**2,496,814,761.63**
Нийт өөрийн хөрөнгийн дүн	**4,065,424,618.96**	**5,166,814,761.63**

ТОДРУУЛГА 8. ХҮҮГИЙН ОРЛОГО

Ангилал	2022.12.31	2023.12.31
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	985,688,911.47	1,436,597,837.44
Хүүгийн орлогын буцаалт	7,770,212.68	558,288,339.63
Банкин дах харилцах дансны хүүгийн орлого	-	35,141.29
Дүн	**977,918,698.79**	**878,344,639.10**

Peace & Perfect Audit
Page № . . 16

"ЦЭНКРЕДИТ ББСБ" ХХК

ТОДРУУЛГА 9. ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ

Ангилал	2022.12.31	2023.12.31
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	-	-
Дүн	-	-
Боловсон хүчний холбогдолтой зардал		
Үндсэн болон нэмэгдэл цалин	56,510,179.12	78,707,708.49
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	6,985,772.38	9,677,714.84
Дүн	**63,495,951.50**	**88,385,423.33**
Бусад зардал		
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	87,297.00	413,800.00
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	2,480,000.00	2,963,900.00
Даатгал	143,000.00	
Түрээс	6,590,790.07	11,547,360.00
Ашиглалтын зардал /цахилгаан, уур ус, дулаан, цэвэр, бохир ус/	1,865,708.01	696,186.98
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	19,472,135.33	19,303,552.00
Харилцаа холбоо, интернет	3,542,639.86	4,409,681.83
Шатахуун болон тээврийн зардал	2,881,158.00	1,148,831.00
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	2,890,000.00	946,000.00
Зохицуулалтын хураамжийн зардал	3,000,000.00	2,700,000.00
Хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах зардал	-	199,499.00
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	1,341,300.00	729,300.00
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	100,000.00	100,000.00
Бичиг хэргийн зардал	357,430.00	1,358,640.00
Ариун цэврийн зардал	348,985.00	218,769.00
Бусад	2,145,841.04	1,677,408.71
Дүн	**47,246,284.31**	**48,412,928.52**
Нийт хүүгийн бус зардлын дүн	**110,742,235.81**	**136,798,351.85**

ТОДРУУЛГА 10. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ

Байгууллагын санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого нь зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, хүүгийн эрсдэл болон гадаад валютын эрсдэл зэргээ байгууллагын үйл ажиллагаанаас хамааран гарч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах зорилгоор удирдаж, бизнесээ хөгжүүлэх шаардлагатай эх үүсвэрүүд хангалттай эсэхийг магадлахад оршино.

Байгууллагын санхүүгийн гол үүрэг хариуцлагууд нь итгэлцлийн өглөг, татварын өглөгүүдээс бүрдэнэ. Компани нь дансны авлага, зээл, хөрөнгө оруулалт, касс дахь бэлэн мөнгө, банкин дахь харилцах данснууд зэрэг олон төрлийн санхүүгийн хөрөнгүүдтэй бөгөөд эдгээр нь байгууллагын санхүүгийн үндсэн үйл ажиллагаанаас үүсдэг.

Байгууллагын санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр, ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж болзошгүй гол эрсдэл нь зах зээлийн эрсдэл, гадаад валютын ханшийн эрсдэл юм.

Иймээс байгууллагын удирдлага нь эдгээр эрсдэлүүд дээр анхаарлаа хандуулан байгууллагын бодлогод тохирч байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг.

Peace & Perfect Audit
Page № . . 17

“ЦЭНКРЕДИТ ББСБ” ХХК

ТОДРУУЛГА 11. ЗОХИСТОЙ БАЙДЛЫН ХАРЬЦАА

Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
А.	**ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**			
1	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	93.8%	Хангасан
2	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	93.8%	Хангасан
3	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	100.0%	Хангасан
Б.	**ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА**			
4	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	9894558.3%	Хангасан
В.	**АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**			
5	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү,- дутуу)	641,004.8	641,004.8	0.0
6	НЭГ ЗЭЭЛДЭГЧ БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	9.7%	Хангасан
14	ББСБ-ААС ГАРГАСАН ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	70%-аас хэтрэхгүй	0.0%	-
8	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ НИЙЛБЭР ДҮНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	25%-аас хэтрэхгүй	3.7%	Хангасан
7	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН, ХОЛБОГДОХ НЭГ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	3.3%	Хангасан
9	ҮНЭТ ЦААСНЫ ЭЗЭМШИЛ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	0.0%	-
10	КОМПАНИЙН ХУВЬЦАА, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
11	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН "I", "II" АНГИЛАЛЫН НЭГ КОМПАНИЙН ГАРГАСАН ХУВЬЦААНААС ХУДАЛДАЖ АВАХ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
12	КОМПАНИЙН ӨРИЙН БИЧИГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
13	БУСАД ҮНЭТ ЦААС, ҮНЭТ ЦААСНЫ ЭЗЭМШЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	#DIV/0!	#DIV/0!
Г.	**ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ**			
15	ГАДААД АКТИВ, ПАССИВЫН ЗӨРҮҮ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	(+/-40%)	0.0%	Хангасан
Д	**БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**			
16	ИПГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	80%-аас хэтрэхгүй	0.0%	-
18	ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	0.0%	-
Е.	**ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**			
17	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	2.8%	Хангасан
Ж.	**ӨГӨӨЖ**			
19	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			10.8%
20	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ			10.8%

Peace & Perfect Audit

ТОДРУУЛГА 12. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрөөс тогтоно. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ гэдэг нь уг хэрэглүүрийн талаар мэдлэгтэй, сонирхож байгаа талуудын хооронд аливаа хөнгөлөлтгүйгээр санхүүгийн хэрэгсэл арилжаалагдах дүн юм.

Хөрөнгийн биржээр арилжаалагдаж, бодит үнэ цэнэ нь биржийн арилжааны ханшаар тодорхойлогддог санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр байхгүй тохиолдолд бодит үнэ цэнийг тухайн хөрөнгө болон өр төлбөрийн чанар болон хугацаанд тохирсон хөнгөлөлтийн хувиар хэмжинэ.

ТОДРУУЛГА 13. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

Байгууллагын хөрөнгийн удирдлагын гол зорилго бол хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд зээлжилтийн үнэлгээг дээгүүр байлгаж, хөрөнгийн харьцааг зохистой түвшинд хангаж ажиллахад оршино.

Компани нь өөрийн хөрөнгийн бүтцийг удирдан өөрчлөлт хийхдээ эдийн засгийн нөхцөл байдал мөн өөрийн үйл ажиллагаанд хамаарах эрсдэлтэй уялдуулдаг. Хөрөнгийн бүтцийг хэвийн хадгалах эсвэл өөрчлөхийн тулд Компани нь хувь нийлүүлэгчдэд төлөх ноогдол ашгийн хэмжээг тохируулан тогтоох, хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг буцаах эсвэл шинээр хувьцаа гаргах зэрэг арга замуудыг ашиглах боломжтой.

Компани нь хөшүүргийн харьцааг (цэвэр өр төлбөрийг нийт капитал ба цэвэр өр төлбөр хоёрын нийлбэрт харьцуулсан харьцаа) ашиглан өөрийн капиталыг хянаж байдаг ба энэ харьцааг аль болох бага байлгах бодлого барьдаг.

Компани нь цэвэр өр төлбөрт иттэлцүүрийн өглөг, бусад өглөг, урт хугацаат өглөгийг оруулах ба мөнгөн хөрөнгийг хасаж тооцно.

ТОДРУУЛГА 14. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Тус компани нь 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар болзошгүй өр төлбөр байхгүй байна.

ТОДРУУЛГА 15. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайланд нөлөөлөхүйц ямар нэгэн ажил гүйлгээ, шийдвэр гараагүй болно.

ТОДРУУЛГА 16. ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ

Энэхүү тайланг “Компанийн тухай” хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн байгууллагын хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Peace & Perfect Audit
Page № . 20